

Mongolian

モンゴル語

Таны хүүхдийн хөгжилд санаа зовоож байгаа зүйл байна уу?

~Япон улсад амьдарч, үр хүүхдээ
хүмүүжүүлж буй эцэг эхчүүдэд зориулав~



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Сэргээн
засалт хөгжлийн үндэсний төв

**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн
мэдээлэл, дэмжлэгийн төв**

Танилцуулга

Япон улсад амьдарч, үр хүүхдээ хүмүүжүүлж буй гадаадын иргэдийн тоо өссөөр байна. Энэхүү гарын авлага нь гадаад улсад амьдардаг, дараах асуудлуудтай тулгарч буй эцэг эхчүүдэд зориулагдсан болно. Үүнд:

- Өөр соёл, амьдралын хэв маягтай оронд эцэг эх байхад тулгарч буй асуудалтай байгаа
- Хүүхдүүдийнхээ хөгжилд санаа тавьж анхаарал хандуулдаг
- Хэлний бэрхшээлээс болж хүүхдэдээ хэрэгтэй мэдээллийг олоход хүндрэлтэй байдаг
- Хүүхдээ өсгөхөд дэмжлэг шаардлагатай байгаа

Хэрвээ та хүүхдийнхээ хөгжлийн талаар санаа зовж, мөн хаашаа явах, хэнээс тусламж авахаа мэдэхгүй эргэлзэж байгаа бол Япон улсад хүүхдийнхээ хөгжилд санаа зовж буй эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлдэг олон байгууллагууд байдаг. Энэхүү гарын авлага нь танд хэрэгтэй байж болох мэдээлэл болоод дэмжлэг олоход нь тусална гэдэгт бид итгэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
Сэргээн засалт хөгжлийн үндэсний төв
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл, дэмжлэг үзүүлэх төв

Агуулга

Хүүхдийнхээ хөгжлийн талаар суралцах

Хүүхдээ анзаарч, ажиглах...	3
Төрснөөс хойш 3 нас хүртэл	3
3 – 6 нас хүртэл (сургуулийн нас)	4
Эрүүл мэндийн үзлэгийг ашиглах нь	5
Нярайн үзлэг	5
18 дахь сарын үзлэг	5
3 насны үзлэг	6
Сургуульд элсэх үеийн эрүүл мэндийн үзлэг	7
Сургуульд орох	7
Тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан сургуулийн сонголтууд	8

Хүүхдийнхээ хөгжлийн талаар зөвлөгөө авах

Зөвлөх үйлчилгээг ашиглах	9
Таны амьдардаг газар дахь зөвлөх үйлчилгээний сонголтууд	10

Хөгжлийн эмгэг гэж юу вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих тухай хууль	12
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төвүүд	12

Эмчид үзүүлэх

Эмчид үзүүлэх, онош ба эмчилгээ	13
Хэрэв таны хүүхдүүд DD оношлогдсон бол ...	13
Эмийн хэрэглээ	14

Хөдөлмөрийн чадвараа алдсаныг илтгэх гэрчилгээтэй танилцах

Ашиг тусын жишээ	15
Оюуны хөгжлийн бэрхшээлийн гэрчилгээ	16
Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлийн гэрчилгээ	16

Нэмэлт мэдээлэл

Гадаад хэл дээрх зөвлөгөө	17
Орчуулгын програмууд	18
Сургуулийн боловсролын талаарх мэдээлэл / Хөгжлийн эмгэгийн талаарх мэдээлэл	19
Англи –Монгол толь бичиг	20

Хүүхдийнхээ хөгжлийн талаар суралцах

Хүүхдээ анзаарч, ажиглах...

Төрснөөс хойш 3 нас хүртэл

- Хэлний хөгжил удаашралтай
- Хэрэглэж байсан үгээ ашиглахаа больсон

- Харилцахад хэцүү, эсвэл нэг үйлдлээр харьцдаг



- Үргэлж ижил тоглоомоор тоглох хандлагатай

- Нүдээр харилцах нь ховор
- Өргүүлэх дургүй
- Нүүрний хувиралд төдийлөн өөрчлөлт гардаггүй
- Нэрээр нь дуудахад хариу үйлдэл үзүүлдэггүй



- Тодорхой зүйлд эсвэл газарт дургүйцлээ хүчтэй илэрхийлдэг
- Нэг хэвийн байдалтай байх (өдөр бүр хийдэг нь зүйл өөрчлөгддөггүй)

- Толгойгоо өргөх, суух, алхах зэрэг хөдөлгөөний хөгжил удаашралтай байх
- Бие султай эсвэл амархан өвддөг

- Ихэнхдээ удаан хугацааны турш уур уцаартай байдаг.
- Өөртөө гэмтэл учруулах үйлдлийг давтан хийдэг. /толгойгоо цохих, гараа хазах гэх мэт/



- Тайван бус
- Үргэлж хөдөлгөөнтэй байнгын анхаарал хандуулах хэрэгтэй байдаг
- Маш амархан сатаардаг



- Олон сарын турш шөнийн цагаар их уйлдаг
- Өдөр унтдаггүй эсвэл унтах нь хүндрэлтэй байдаг
- Хоолоо хэт голдог



- Дуу чимээнд хариу үйлдэл үзүүлдэггүй
- Дуу чимээнд мэдрэг байдаг уу? (чихээ таглах)



3 – 6 нас хүртэл (сургуулийн нас)

- Бусад хүүхдүүдтэй харилцдаггүй эсвэл бусад хүүхдүүдтэй тоглодоггүй
- Цөөн зүйлд сонирхолтой байдаг
(тодорхой өнгө, барааны тэмдэг, тэмдэг, үсэг, тоо гэх мэт)
- Адилхан асуултууд эсвэл сэдвүүдийн хүрээнд дахин дахин давтан асуудаг
- Ихэнхдээ ганцаараа цагийг өнгөрөөдөг



- Дүрэм журам, амлалтыг тоодоггүй
- Нэг талт яриа эхлүүлж, дуусгадаг
- Найзуудтайгаа тоглох тийм ч дуртай биш эсвэл дээрэлхдэг
- Тайван бус, байнгын хөдөлгөөнтэй байдаг
- Бие даан өөрөө гадуур явдаг
- Заавар, тайлбар дуустал нь сонсдоггүй



- Багийн ажилд бусад хүүхэд шиг идэвхтэй оролцдоггүй
- Бэлдэх эсвэл эмхлэх цэгцлэхдээ их цаг зарцуулдаг
- Зураг зурах, хайч ашиглахдаа муу
- Биедээ хүргэх дургүй
- Бие засах, хувцас солих зэрэг хувийн үйлдэлд суралцахдаа муу



- Ихэнхдээ бусад хүмүүс өөртэй нь ярилцаж байгааг мэддэггүй
- Үсэг болон тоог сайн ойлгодоггүй
- Хамгийн сайн чаддаг зүйл эсвэл хийж чаддаггүй зүйлс байдаг эсэх



Хүүхдийн иймэрхүү зан байдал, хандлага нь эцэг эхийн санаа зовох эх үүсвэр болдог.

Та болон танай гэр бүл хүүхдээ асуудалтай юм болов уу гэж бодож бухимдаж байж магадгүй эсвэл сайн эцэг эх байж чадахгүй байгаадаа сэтгэл зовниж байж ч магадгүй юм.

Ийм зан төлөв нь түр зуурын шинжтэй байж болох ч таны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсвэл хөгжлийн гажигтай байж болзошгүй юм.

Эрүүл мэндийн үзлэгийг ашиглах

Орон нутгийн засаг захиргаа болгон нялх хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийг үнэ төлбөргүй хийдэг. Энэ нь таны хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн талаар мэдэх чухал боломж тул үзлэгийг ашиглах нь зүйтэй.

Үзлэгийн хуваарийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг газар нутаг бүр өөр өөр хуваарийн дагуу дагаж мөрдөж байдаг тул орон нутгийн засаг захиргаатай холбоо барих хэрэгтэй.

Нярайн үзлэг

Хэзээ авдаг вэ?

Таны хүүхэд 3-4 сартай байх үед

Ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?

- Эмчийн үзлэг
- Өндөр ба жинг шалгах
- Хэрэв танд санаа зовох зүйл байвал нийгмийн эрүүл мэндийн сувилагчтай зөвлөлдөх
- Хоол тэжээлийн мэргэжилтний зөвлөмж

18 дахь сарын үзлэг

Хэзээ авдаг вэ?

Таны хүүхэд 18 сар болсны дараа, 24 сар хүрэхээс өмнө

Ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?

- Эмчийн үзлэг
- Шүдний эмчийн үзлэг
- Өндөр ба жинг шалгах
- Хэрэв танд ямар нэгэн асуудал байгаа бол нийгмийн эрүүл мэндийн сувилагчтай зөвлөлдөх



3 насны үзлэг

Хэзээ авдаг вэ? Хүүхэд 3 нас хүрсний дараа, 4 нас хүрэхээс өмнө

Ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?

- Эмчийн үзлэг
- Шүдний эмчийн үзлэг
- Өндөр ба жинг шалгах
- Шээсний шинжилгээ
- Хараа ба сонсголын тестүүд
- Хэрэв танд ямар нэгэн асуудал

байвал нийгмийн эрүүл мэндийн сувилагч,
хоол тэжээлийн мэргэжилтэн, сэтгэл зүйчтэй
зөвлөлдөх



- **Харааны тест**

Нүдний хараа нь ойролцоогоор зургаан нас хүртлээ хөгжсөөр байдаг. Нүдний харааны гажиг эсвэл нүдний хяларын эрт илрүүлэлт болон эмчилгээ нь сайн урьдчилан сэргийлж чаддаг.

- **Сонсголын тест**

Энэхүү шинжилгээгээр таны хүүхэд сонсголын бэрхшээлтэй эсвэл чихний өвчтэй эсэхийг шалгана. Сонсгол нь хэлний хөгжилд нөлөөлдөг тул эрт илрүүлэх нь чухал байдаг.



- ☐ Таны хүүхэд тодорхой насны хязгаарт хүрсэн тохиолдолд л үзлэг хийх боломжтой.
- ☐ Үзлэг бүр үнэ төлбөргүй бөгөөд зөвлөгөө авахад нэмэлт төлбөр төлөхгүй.
- ☐ Хэрэв үзлэг хийх өдрөөсөө хоцорсон бол харьяа орон нутгийн захиргааны байгууллагатай холбоо бариарай

Сургуульд элсэх үеийн эрүүл мэндийн үзлэг

Хэзээ авдаг вэ?

Хүүхдүүд 6 насны төрсөн өдрөөсөө хойш 4-р сард сургуульд орох тул сургууль эхлэхээс өмнө 9-р сарын орчимд орон нутгийн боловсролын зөвлөлөөс танд мэдэгддэг. (Хэрвээ хүүхэд тань харьяалалгүй, эсвэл гадаадын харьяалалтай бол Японы бага сургуульд элсэх өргөдлийг орон нутгийн зөвлөлд өгөх шаардлагатайг анхаарна уу.)

Ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?

- Таны хүүхэд элсэн орж буй бага сургуульд зохион байгуулагддаг.
- Эмчийн үзлэг
- Шүдний эмчийн үзлэг
- Өндөр ба жинг шалгах
- Хараа ба сонсголын тестүүд
- Богино хэмжээний оюун ухааны тест

Сургуульд орох

Орон нутгийн боловсролын зөвлөл болон боловсролын төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд мөн бага сургуулийн орчин дахь асуудлын талаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Сургуулийн өмнөх болон цэцэрлэгийн багш нар дээр дурдсан зөвлөлтэй зөвлөлдөхийг санал болгодог.

Сургуульд орох зөвлөгөөг зөвхөн уулзалтаар хийдэг. Орон нутгийн боловсролын зөвлөлтэй холбоо барьж цаг авах шаардлагатай.

● Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан боловсрол

Боловсролын зөвлөлөөс аль төрлийн сургууль хүүхдэд хамгийн тохиромжтой болохыг эцэг эх, хүүхдийн хүслийг хүндэтгэн үзэж, шийдвэрлэдэг.

Бага сургуулиудад янз бүрий тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатайхүүхдэд зориулсан **"Тусгай ангиуд"** мөн ердийн ангид элсэн орох хүүхдэд зориулсан тусгай зааварчилгаа авдаг өрөө тус тус байдаг. Түүнчлэн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан **"Тусгай хэрэгцээт боловсролын сургууль"** мөн байдаг.

Та тусгай анги эсвэл тусгай хэрэгцээт боловсролын сургуультай танилцаж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг харьяа нутгийн боловсролын зөвлөлөөс авна уу.

Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд зориулсан сургуулийн сонголтууд

Бага, Дунд сургууль

Ердийн анги

Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд ердийн орчинд нэмэлт анхаарал, дэмжлэг хэрэгтэй.

Тусгай сургалтын өрөө

Тусгай сургалт нь сард эсвэл долоо хоногт цөөн хэдэн удаа ордог ба бусад сургалтын хөтөлбөрийн агуулгыг ердийн танхимын хичээлээр дамжуулан үздэг.

Хүүхэд өдөр тутмын амьдралын ур чадвараа сайжруулах эсвэл хичээлээ давтахын тулд бие даан суралцах боломжтой.

Тусгай ангиуд

Ангиудын хэмжээ бага.

Ямар төрлийн Хөгжлийн бэрхшээл гэдгээс нь хамааран зургаан төрлийн тусгай анги байдаг:

Харааны болон сонсголын бэрхшээл, оюуны хомстол, бие бялдрын хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал, аутизм, сэтгэл санааны тайван бус байдал. Сургуулиудын хувьд өөр хоорондоо анги танхимын төрөл, тоо ялгаатай байдаг.

Тайлбар: Сургууль болгонд тусгай хэрэгцээний систем, нөөцийн өрөө байдаггүй.

Тусгай хэрэгцээт боловсролын сургууль

Энэ нь харааны бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй, бие бялдрын, эрүүл мэндийн болон оюуны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургууль юм. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургууль нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй аутизмын спектрийн эмгэгтэй (ASD) хүүхдийг хүлээн авдаг. Анги дүүргэлтийн хэмжээ бага, сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээл тус бүрт зориулан боловсруулан гаргадаг.

Хүүхдийнхээ хөгжлийн талаар зөвлөгөө авах

Зөвлөх үйлчилгээг ашиглах



Хувь хүний хөгжил болон зан чанар нь хүүхэд бүрт өөр өөр байдаг. Ямар нэгэн асуудал тулгарвал тухайн асуудлыг зохих ёсоор нь шийдвэрлэхийн тулд эртхэн зөвлөлдөх нь чухал

- Хүүхдээ хүмүүжүүлэх, хөгжүүлэхтэй холбоотой асуудлаар орон нутгийн засаг захиргааны нийгмийн эрүүл мэндийн сувилагчтай зөвлөлдөх;
- Хэрэв танай хүүхэд сургуулийн өмнөх болон цэцэрлэгт хамрагдаж байгаа бол багш нартай нь хүүхдээ анги хамт олонтойгоо хэрхэн харилцдаг тухай тогтмол ярилцах;
- Харьяа орон нутгийн засаг захиргааны хөгжлийн зөвлөхүүдээр дамжуулан, цэцэрлэгийн насны хүүхдийнхээ талаар ганцаарчилсан эсвэл байгаа газраасаа интернетээр холбогдон зөвлөгөө авах боломжтой.
- Орон нутгийн засаг захиргаа нь хүүхдийн хөгжлийн үе шатанд тохирсон хүүхэдтэйгээ хэрхэн зөв зохистой харьцаж сурах талаар эцэг эх, мөн хүүхдүүдэд зориулсан бүлгийн семинар зохион байгуулдаг.

Бусад зөвлөх үйлчилгээний хувилбарууд:

- Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, нийгмийн эрүүл мэндийн төв
- Хүүхдийн хөгжлийг дэмжих төв
- Эцэг эхчүүдийг дэмжих төв, хүүхдүүд, эцэг эхчүүдийг цуглуулах (tsudoi-no hiroba)

Тайлбар: Зөвлөх үйлчилгээний талаарх мэдээлэл нь орон нутаг бүрт харилцан адилгүй байдаг учир дэлгэрэнгүй мэдээллийг харьяа орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн төвийн сувилагчтай холбогдон аваарай.

Таны амьдардаг газар дахь зөвлөх үйлчилгээний сонголтууд

Орон нутгийн засаг захиргаа бүрт зөвлөх үйлчилгээ олон төрлийн хувилбартай байдаг. Хэрэв танд хүүхдийнхээ талаар санаа зовоосон асуудал байгаа бол эдгээр үйлчилгээг ашиглаарай.

Байгууллага	Зөвлөх мэргэжилтэн	Нээх цаг	Утас	Орчуулагч
	Зөвлөх чиглэл			
[Жишээ] XYZ хотын хүүхэд хөгжлийн төв	18-аас доош насны хүүхдүүд, эцэг эхчүүд,	Даваа-Баасан гараг, 9-17 цагийн хооронд. Амралтынбаярын өдрүүдэд ажиллахгүй	(04) 000-000	Хэсэгчлэн авах боломжтой (Хэлнүүд)
	Жишээлбэл. Хүүхдийн хөгжил, хөгжлийн үнэлгээ, жирэмслэлт, төрөлт, эцэг эх			

Хөгжлийн эмгэг гэж юу вэ?

Хөгжлийн эмгэг (DD) нь тархины үйл ажиллагааны хөгжлийн хомсдолтой байдаг ба ихэнх тохиолдолд төрөлхийн байдаг. Хөгжлийн эмгэгүүд нь доор үзүүлсэнчлэн нэг ижил эмгэгтэй хүмүүс хүртэл өөр хоорондоо ялгаатай шинж тэмдэг үзүүлдэг янз бүрийн хэлбэрүүд байдаг.

Магадгүй оюуны хөгжил нь удаан явагдаж байж болно.

Хөгжлийн эмгэгийн тархалт (Аутист спектрийн эмгэг; ASD)

Аутист

Аспергерын хам шинж

- Хэлний саатал (Аспергерийн синдромд ажиглагддаггүй)
- Харилцаа холбооны бэрхшээлтэй байдал
- Нийгмийн харилцааны асуудлууд
- Ритуализаци / хэвшмэл зан байдал, сонирхол
- Хэт эмзэг мэдрэг, удаан хариу үйлдэлтэй

Анхаарал хэт сулрах идэвхжилийн эмгэг (ADHD)

- Анхаарлаа төвлөрүүлэх боломжгүй
- Хөдөлгөөнгүй байх боломжгүй
- Түргэн цочмог зан авиртай байх

Сурах эмгэг (LD) (Онцгой сурах эмгэг; SLD)

- Унших, бичих, тооцоолох зэрэгт ихээхэн бэрхшээлтэй байдаг.

Тайлбар: Tourette синдром, Ээрч гацах, Хөгжлийн уялдаатай эмгэг гэх мэт хөгжлийн эмгэг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих тухай хууль дахь хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолт:

"Хөгжлийн эмгэгүүд нь тархины үйл ажиллагааны хомсдол болох аутизм, Аспергерын синдром, бусад түгээмэл хөгжлийн бэрхшээл, сурах эмгэг, хүүхэд насны анхаарал хэт сулрах идэвхжилийн эмгэг зэрэг орно."

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэг нь өдөр тутмын болон нийгмийн амьдралд оролцоходоо нийгмийн хориг болон хөгжлийн бэрхшээлийн улмаас хязгаарлалтад орохыг хэлнэ.

Нэмэлт: Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох өөр нэг арга бол ICD-10 доторх F80-98 хүртэлх эмгэгүүд орно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих тухай хууль

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих тухай хууль бол хөгжлийн эмгэгтэй хүүхдүүд (наснаас үл хамааран) болон тэдний гэр бүлд дэмжлэг үзүүлэх зорилгоор үндэслэгдсэн Японы хууль юм.

Энэхүү хууль нь хөгжлийн эмгэгтэй хүүхдүүд өөрсдийн чадвар чадамжийг ойлгон ухамсарлан мөн гэр бүл нь тэднийг аюулгүй найдвартай орчинд өсгөх боломжоор хангадаг нийгмийг бүтээх зорилготой.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төвүүд

Японы муж бүрт хөгжлийн эмгэгтэй хүмүүст болон тэдний гэр бүлийнхэнд зөвлөх үйлчилгээ, мэдээлэл дэмжлэг үзүүлдэг төвүүд байдаг. Муж, хот болгон Хөгжлийн бэрхшээдэмжих төв тэй бөгөөд төрөл бүрийн мэдээлэл, дэмжлэг үзүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг.

Дэмжлэг үзүүлдэг төвүүдийн талаарх мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, дэмжлэгийн төв

<https://www.rehab.go.jp/ddis/>



Тухайн харьяа бүс нутаг дахь хөгжлийн эмгэгтэй (DD) иргэдийг дэмжих төв

Нэр:

Холбоо барих:

Эмчид үзүүлэх



Эмчид үзүүлэх, онош ба эмчилгээ

Японд хөгжлийн эмгэгийн оношийг хүүхдийн эмч, хүүхдийн сэтгэцийн эмч гэх мэт нарийн мэргэжлийн эмч нар тодорхойлдог. Хэрэв та эмчид үзүүлэхийг хүсвэл:

- Орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн сувилагчаас эсвэл хөгжлийн эмгэгтэй хүмүүсийг дэмжих төвд хандах хэрэгтэй. (эмнэлгүүдэд цаг аван үйлчлүүлэх шаардлагатай байдаг.)
- Анхны эмчийн үзлэгт хүүхдийнхээ эрүүл мэндийн даатгалын дэвтэр, Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг авч очих шаардлагатай байдаг.
- Эмчдээ хандан таны санаа зовж байгаа асуудал, таны хүүхэд гэртээ эсвэл цэцэрлэгт хэрхэн байдаг талаар бичих хэрэгтэй.

Онош болон эмчилгээ



Мэргэжлийн эмч нар таны хүүхдийн хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан оношилж, эмчилгээ хийдэг. Уг оношлогоонд оюун ухаан, хөгжлийн тест, сонсголын тест, электроэнцефалографи орно. Харин ганцаарчилсан эмчилгээнд физик эмчилгээ, мэргэжлийн эмчилгээ, хэл ярианы сонсголын эмчилгээ, сэтгэлзүйн эмчилгээ ордог.

Хэрэв таны хүүхэд хөгжлийн эмгэгтэй оношлогдсон бол ...

Таны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг мэдэх хэцүү байх хэдий ч хүрээлэн байгаа орчин болон түүнтэй харилцах харилцааны тал дээр эмч, мэргэшсэн ажилтнуудтай зөвлөлдөн таны хүүхдэд юу тохирохыг ярилцаж, олж мэдэх нь хүүхдийн хөгжлийн үр дүнд эерэгээр нөлөөлж болно.

Эмийн хэрэглээ

Эмч таны хүүхдийг тайван амгалан байхад нь туслах эмийг санал болгодог ба тэдгээр эмнүүдийн талаарх үр нөлөө болон сөрөг нөлөөг мэддэг байх нь чухал. Эм уух нь хөгжлийн эсгэгийг шууд эмчлэхгүй боловч түгээмэл тохиолддог зарим шинж тэмдэг зовиурыг намдааж өгдөг.

Тогтмол хэрэглэгддэг эмүүд

- Төв мэдрэлийн систем идэвхжүүлэх эм: Анхаарал хэт сулрах идэвхжлийн эмгэгийн хэт идэвхжилт, анхааралгүй байдал, мэдрэмтгий байдлыг бууруулахад тусална.
- Тайвшруулах эм: сэтгэл түгших, бусад таагүй мэдрэмжүүдийг багасгах
- Сэтгэц мэдрэлийн эм: Хүчтэй цочрол, төөрөгдлийг намдаана
- Унаж татах өвчний эм: уналт, таталтыг хянахад тусалдаг
- Нойрны эм: Унтах эрүүл зуршлыг бий болгох

Эм уух нь зовиуртай шинж тэмдгийг бууруулах замаар таны хүүхдийг илүү амар тайван байхад тусалдаг тул эмийг зааврын дагуу оновчтой тун , давтамжтай хэрэглээрэй.

- ☆ Хэрвээ танд мэргэжлийн эмчийн тайлбараас ойлгомжгүй зүйлс байвал цаг алдалгүй асууж тодруулаарай.
- ☆ Мөн нийгмийн эрүүл мэндийн сувилагч болон цэцэрлэгийн багш нартай хүүхдээ хэрхэн яаж байгааг тогтмол хуваалцаж, ярилцсанаар мэргэжлийн хүмүүстэй хамт хянах боломжтой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан гэрчилгээ

Ашиг тусын жишээ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан гэрчилгээтэй байх нь хөгжлийн бэрхшээлийн төрөл, хүнд байдлаас хамаарч янз бүрийн халамжийн үйлчилгээ, тэтгэмж авах боломжийг олгодог. Та гэрчилгээгээ орон нутгийн засаг захиргааны байгууллагаас авах ёстой. Тахир дутуугийн төрөлд харгалзах дараах гурван төрлийн гэрчилгээ байдаг:

Оюуны хөгжлийн бэрхшээлийн гэрчилгээ (нөхөн сэргээх гэрчилгээ), сэтгэцийн хөгжлийн бэрхшээлийн гэрчилгээ, бие махбодын хөгжлийн бэрхшээлийн гэрчилгээ.

- ☐ Гэрчилгээтэй байх нь халамжийн үйлчилгээ авахад хялбар байдаг.
- ☐ Тэтгэмжийн хэмжээ нь хөдөлмөрийн чадвар алдалтын төрөл, хүндийн зэргээс хамаарна.
- ☐ Иргэдэд үзүүлэх халамж үйлчилгээ нь орон нутгийн засаг захиргаа бүрт ялгаатай байдаг.

Дэлгэрэнгүй мэдээллийг орон нутгийн засаг захиргааны нийгмийн халамж хариуцсан хэлтсээс авна уу.

Ашиг тусын жишээ

- Тэтгэмж
- Эмчилгээний зардлыг хэсэгчлэн нөхөн төлөх
- Татварын хөнгөлөлт
- Галт тэрэг, автобус, дотоодын онгоцны тийзийн хөнгөлөлт
- Төлбөртэй авто замын хөнгөлөлт....

Оюуны хөгжлийн бэрхшээлийн гэрчилгээ

Хэн хамрагдах вэ?

- Оюуны бэрхшээлтэй хүн
- Хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүн



Хэрхэн хамрагдах вэ?

- 18-аас доош насны хүүхдэд зориулсан Хүүхдийн чиглүүлэх төв, 18-аас дээш насныханд зориулсан оюуны бэрхшээлтэй хүмүүст зориулсан нөхөн сэргээх зөвлөгөө өгөх төвд хүндийн зэргийг нарийвчлан тодорхойлох оношлогооны тест авдаг.

Нэмэлт тайлбар: Цаг хугацаа өнгөрөх тусам хүний оюуны хөгжлийн бэрхшээлийн зэрэг өөрчлөгдөж болзошгүй тул муж бүрээс тогтоосон тодорхой мөчлөгт хугацааны дараа хүндийн зэргийг дахин оношлуулах шаардлагатай.

Сэтгэцийн эмгэгийн гэрчилгээ

Хэн хамрагдах вэ?

- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлийн улмаас амьжиргааны дэмжлэг шаардлагатай байгаа хүмүүс:
 - Хөгжлийн эмгэг
 - Шизофрени
 - Сэтгэлийн эмгэг (жишээлбэл, сэтгэлийн хямрал, хоёр туйлт эмгэг)
 - Эпилепси
 - Мансууруулах бодист донтох
 - Дээд тархины үйл ажиллагааны алдагдал
 - Бусад сэтгэцийн эмгэг (жишээлбэл, стресстэй холбоотой эмгэг)

Хэрхэн хамрагдах вэ?

- Нутгийн захиргааны байгууллагын халамжийн хэлтэс дээр очих
- Дараах баримт бичгийг авчирна уу:
 - 1) Эрүүл мэндийн гэрчилгээ (эсвэл шаардлагатай бол тахир дутуугийн тэтгэвэр авагчийн гэрчилгээ)
 - 2) Хүсэлт гаргаж буй хүний зураг
- Анкет бөглөх (лангуун дээрээс авах боломжтой)

Нэмэлт тайлбар: Гэрчилгээг хоёр жил тутамд сунгах ёстой. Шинэчлэн сунгах гэрчилгээ бүрт өмнөх гэрчилгээг хамт авчрах шаардлагатай.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Зарим эмнэлэг, зөвлөх байгууллагуудад гадаад гэр бүлд үйлчилгээ үзүүлэхийн тулд орчуулгын програм ашиглах эсвэл гадаад хэлээр ярьдаг ажилтантай байдаг. Мөн орчуулгын үйлчилгээ авахад тусалдаг.

Гадаад хэл дээрх зөвлөгөө

адаадын оршин суугчдад зориулсан утсаар зөвлөх үйлчилгээ өгдөг олон байгууллагууд байдаг. Эдгээр байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр мэргэшээгүй ч гэсэн танд шаардлагатай байгаа эмнэлэг болон орчуулгын үйлчилгээний газартай холбож өгдөг.

◆ адаадын оршин суугчдад зориулсан бодлогын талаархи цахим сайт

Энэхүү сайтад гадаад хэл дээрх зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын утасны жагсаалтыг мужаар нь ангилан бичсэн байгаа.



<http://www.moj.go.jp/isa/support/portal/index.html>

◆ AMDA Олон улсын эрүүл мэндийн мэдээллийн төв

Тус төв нь гадаадын оршин суугчдад зориулсан эмнэлгийн халамжийн тогтолцооны талаарх болон төрөлх хэлээрээ ойлголцох боломжтой эмнэлгийн байгууллагуудын утасны мэдээллийн үйлчилгээг үзүүлдэг. Үйлчилгээний ажилтан нь энгийн ойлгоход хялбар Япон хэлээр ярьдаг



Токио оффис

Утас: 03-6233-9266 (Даваа-Баасан, 10:00-15:00)

<https://www.amdamedicalcenter.com/>

Орчуулгын програмууд

◆ VoiceTra Мэдээлэл, харилцаа холбооны үндэсний хүрээлэн

Энэхүү програм нь Японы ярианы орчуулгыг 31 орны хэлээр хөрвүүлдэг. Та энэ програмыг үнэгүй татан авч ашиглах боломжтой..

<http://voicetra.nict.go.jp/>



Сургуулийн боловсролын талаарх мэдээлэл

◆ MEXT-ийн мэдээллийн цахим хуудаснууд

○ CLARINET (Япон хэл дээр)

Хилийн чанадад амьдардаг Япон хүүхдүүд, гадаадаас буцаж ирсэн япон хүүхдүүд, гадаад хүмүүст зориулсан боловсролын талаарх мэдээлэл өгдөг
https://www.mext.go.jp/a_menu/shotou/clarinet/main7_a2.htm



○ CASTA-NET (Япон хэл дээр)

Нутагтаа буцаж ирсэн болон гадаадын оюутнуудын сурахад дэмжлэг үзүүлэх зорилготой боловсролын мэдээллийн цахим хуудас
<https://casta-net.mext.go.jp/>



○ MUSE төсөл (Гадаад хэлний боловсролыг дэмжих)(япон хэл дээр)

Гадаад гэр бүлийг сургуультай нь холбох зорилготой олон орны хэл дээрх материалаар хангадаг.
<https://data.casta-net.mext.go.jp/tagengo-gakko.jp/index.html>



Хөгжлийн эмгэгийн талаархи мэдээлэл

○ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл, дэмжлэгийн төв (Япон хэл дээр)

Хөгжлийн эмгэгийн талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, тэдгээрийн онцлог шинж чанар, түүнтэй харилцах стратеги, хөгжлийн эмгэгтэй хүмүүст зориулсан дэмжлэгийн систем, дотоодын болон дэлхийн чиг хандлагын талаарх мэдээлэл өгдөг
<https://www.rehab.go.jp/ddis/>



○ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусламжийн төв (Япон хэл дээр)

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд заах арга барил, материал, туслах хэрэгслийн талаарх мэдээлэл өгөх, хөгжлийн бэрхшээлийн талаарх судалгаа, багш нарт зориулсан видео лекц, холбогдох засгийн газрын бодлого, дүрэм журам.
http://icedd_new.nise.go.jp/



Англи-Монгол толь бичиг

	Англи	Цагаан толгой дээрх Япон хэл	Монгол
A	Act on Support for Persons with Developmental Disorders	Hattatsu shōgai sha shien hō	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих тухай хууль
	ADHD	Chūi kekkan tadōsē shōgai/ADHD	Анхаарал хэт сулрах идэвхжлийн эмгэг /ADHD
	Allowance	Teate	Тусламж эмчилгээ
	Anti-anxiety medication	Kō fuan yaku	Сэтгэц сэргээх бэлдмэл
	Antiepileptic medication	Kō tenkan yaku	Унадаг өвчнийг эмчлэх бэлдмэл
	Antipsychotic medication	Kō seishinbyō yaku	Тайвшруулагч эм
	Appointment	Yoyaku	Захиалга
	Assessment	Kensa	онош
	Auditory test	Chōkaku kensa	Сонсголын шинжилгээ
	Autism/autism spectrum disorder	Jiheishō/ASD	Аутизм /ASD
B	Baby health checkup (checkup)	Nyūyōji kenkō shinsa (kenshin)	Нярайн эрүүл мэндийн үзлэг (эмнэлгийн үзлэг)
	Bipolar disorder	Sōkyokusē shōgai	Биполар дисордер
	Board of education	Kyōiku iinkai	Боловсролын зөвлөл
C	Central nervous system stimulants	Chūsū shinkei shigeki yaku	Төв мэдрэлийн тогтолцоог сэргээх эм
	Certificate for Persons with Disabilities	Shōgaisha techō	Хөгжлийн бэрхшээлтэй хүний дэвтэр
	Child Guidance Center	Jidō sōdanjo	Хүүхдийн зөвлөгөө өгөх газар
	Child psychiatrist	Jidō seishinkai	Хүүхдийн сэтгэл мэдрэлийн эмч
	Consultation	Sōdan	Зөвлөгөө
D	Dentist	Shikaishi/haisha	Шүдний эмч
	Depression	Utsu	Сэтгэл гутрал
	Development	Hattatsu	Өсөл торнилт
	Developmental coordination disorder	Hattatsu sē kyōchō undō shōgai	Өсөлтийн хөдөлгөөний эмгэг
	Developmental disorders	Hattatsu shōgai	Хөгжлийн эмгэг
	Developmental test	Hattatsu kensa	Торнилтын шинжилгээ
	Diagnosis	Shindan	Онош
	Disability	Shōgai	Саатал, эмгэг
	Disability pension	Shōgai nenkin	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр
	Doctor (physician)	Ishi/isha	Эмч
	Drug addiction	Yakubutsu izon shō	Эмийн донтол
E	Education center	Kyōiku sentā	Боловсролын төв
	Effects	Kōka/sayō	Үр дүн /нөлөө

	Eighteen-month (1 year and a half) checkup	Issai rokkagetsuji kenkō shinsa (kenshin)	1 нас 6 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэг (эмнэлгийн үзлэг)
	Electroencephalography	Nōha kensa	Тархины цахилгаан бичлэгийн шинжилгээ
	Elementary school	Shōgakkō	Бага сургууль
	Emotional disturbance	Jōcho shōgai	Сэтгэлийн хямрал
	Epilepsy	Tenkan	Унадаг өвчин
H	Health checkup on admission to school	Shūgakuji kenkō shindan	Сургуульд орох үеийн эрүүл мэндийн үзлэг
	Health impairment	Byōjaku/Shintai kyojaku	Биетэй султай
	Health insurance card	Hoken shō	Эрүүл мэндийн карт
	Hearing impairment	Nanchō	Чих хатуурах
	Higher brain dysfunction	Kōjinō kinō shōgai	Тархины эмгэг
	Hospital	Byōin	Эмнэлэг
I	Individual consultation	Kobetsu sōdan	Хувийн зөвлөгөө
	Infant checkup	Nyūji kenshin	Нярай хүүхдийн эрүүл мэндийн үзлэг
	Information and Support Center for Persons with Developmental Disorders	Hattatsu shōgai jōhō shien sentā	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл, дэмжлэгийн төв
	Intellectual Disability Certificate (Rehabilitation Certificate)	Ryōiku techō	Эмчилгээний дэвтэр
	Intellectual disability	Chiteki shōgai	Сэтгэцийн эмгэг
	Intelligence test	Chinō kensa	Оюун ухааны шинжилгээ
J	Junior high school	Chūgakkō	Дунд сургууль
K	Kindergarten	Yōchien	Цэцэрлэг
L	Learning disorder	Gakushū shōgai/LD	Сурах чадваргүйдэл /LD
	Low vision	Jakushi	Харааны бэрхшээл
M	Maternal and Child Health Handbook	Boshi kenkō techō (Boshi techō)	Эх үрсийн эрүүл мэндийн дэвтэр (Boshi techō)
	Medical certificate/medical card	Shindansho	Онош бичиг
	Medication	Kusuri	Эм
	Mental Disability Certificate	Seishin shōgaisha hoken fukushi techō	Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл мэнд, нийгмийн халамжийн дэвтэр
	Mood disorders	Kibun shōgai	Сэтгэлийн эмгэг
N	Nutritionist	Eiyōshi	Хоол судлалын эмч
O	Occupational therapy	Sagyō ryōhō	Хөдөлмөр эмчилгээ
	On-site consultation	Junkai sōdan	Эргүүлийн зөвлөгөө
P	Parenting support center	Kosodate shien sentā	Хүүхэд хүмүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төв
	Pediatrician	Shōnikai	Хүүхдийн эмч
	Physical disability	Shitai fujiyū/shintai shōgai	Бие махбодын хөгжлийн бэрхшээл
	Physical Disability Certificate	Shintai shōgaisha techō	Бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэвтэр
	Physical therapy	Rigaku ryōhō	Физик ба нөхөн сэргээх эмчилгээ

	Preschool	Hoikuen	Цэцэрлэг
	Preschool teacher	Hoikushi	Цэцэрлэгийн багш
	Promotion Center of Education for Persons with Developmental Disorders	Hattatsu shōgai kyōiku suishin sentā	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролыг дэмжих төв
	Psychologist	Shinrishi	Сэтгэл зүйч
	Psychotherapy	Shinri ryōhō	Сэтгэл зүйн эмчилгээ
	Public health nurse	Hokenshi	Нийгмийн халамжийн ажилтан
	Public health center	Hoken sentā	Нийгмийн халамжийн төв
R	Rehabilitation Counseling Center for Persons with Intellectual Disabilities	Chiteki shōgaisha kōsei sōdanjo	Оюуны бэрхшээлтэй иргэнийг сэргээн засах зөвлөгөө өгөх газар
	Resource room	Tsūkyū shidō kyōshitsu	Тусгай сургалтын анги
	Regular classroom	Tsūjō gakkū	Ердийн анги
S	Schizophrenia	Tōgō shicchō shō	Шизофрени
	School entry	Shūgaku sōdan	Сургуульд орох зөвлөгөө өгөх
	School for special-needs education	Tokubetsu shien gakkō	Тусгай хэрэгцээт боловсролын сургууль
	Side effects	Fuku sayō	Сөрөг нөлөө
	Sleeping pills	Suimin yaku	Нойрны эм
	Specialized staff	Senmon sutaffu	Мэргэжлийн ажилтан
	Special-needs classroom	Tokubetsu shien gakkū	Тусгай хэрэгцээт боловсролын анги
	Speech-language-hearing therapy	Gengo chōkaku ryōhō	Хэл яриа, сонсголын эмгэг судлал засал
	Stress-related disorder	Sutoresu sē shōgai	Стрессийн гаралтай эмгэг
	Stuttering	Kitsuon	Ээрч гацах
	Support Center for Persons with Developmental Disorders	Hattatsu shōgai sha shien sentā	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих төв
	Support center for child development	Kodomo hattatsu shien sentā	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төв
T	Three-year checkup	Sansai ji kenkō shinsa (kenshin)	3 настай хүүхдийн эрүүл мэндийн үзлэг (эмнэлгийн үзлэг)
	Tourette syndrome	Turetto shōkōgun	Туреттийн хам шинж
	Translator (with oral language)	Tsūyaku	Орчуулга
V	Vision test	Shikaku kensa	Сонсголын сорил
W	Welfare service	Fukushi sābisu	Нийгмийн халамжийн үйлчилгээ



Таны хүүхдийн хөгжилд санаа зовоож байгаа зүйл байна уу?

~Япон улсад амьдарч, үр хүүхдээ хүмүүжүүлж буй эцэг эхчүүдэд зориулав~〔Монгол хэл〕

Хэвлэл

2021 оны 3-р сар / 2025 оны 3-р сар: Дизайн засвар

Редакцийн хянагч

Доктор Осаму Такахаши, Тоёота хотын Нийгмийн халамжийн корпорацийн ТУЗ-ийн дарга

Хамтран ажилласан

Олон нийтийн оролцоот зөвлөгөөний танхим, Тоёота хүүхдийн хөгжлийн төв

Редактор, Продюсер

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжихэд чиглэсэн олон орны гарын авлага болон бусад материалыг боловсруулах ажлын хэсэг (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн мэдээллийн шинжилгээний хурал)

Хэвлэн нийтлэгч

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл, дэмжлэгийн төв Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Сэргээн засалт хөгжлийн үндэсний төвийн Төлөвлөлт, мэдээллийн хэлтэс

Хаяг: 4-1 Намики, Токорозава-ши, Сайтама 359-8555, Япон

Цахим хуудас: <https://www.rehab.go.jp/ddis/>

Design and illustration Kuu Kusuvara

Design cooperation Simple Communication Association (General Incorporated Association)

イラスト・デザイン くすはらくう

デザイン協力 一般社団法人やさしいコミュニケーション協会

The design and illustration of this booklet were funded by:

Health Labour Science Public Administration Research Project Grant, *Shogaisha sogo hukushiho-no taisho hani-no kento-to shogai hukushi keikaku-no sakusei-ni muketa deta rikatsuyo-no shuho-no kakuritsu-ni kansuru kenkyu* (Research on examining the scope of the Act for the Comprehensive Support of Persons with Disabilities and establishing a method for using data for plans for welfare of persons with disabilities; Primary researcher: Kumiko Imahashi)

このパンフレットのデザイン・イラストは以下の研究費により制作されました。

厚生労働科学行政推進調査事業費「障害者総合支援法の対象範囲の検討と障害福祉計画の作成に向けたデータ利活用の手法の確立に関する研究」
(研究代表: 今橋久美子)



[Guideline for use of this booklet] You are free to print and distribute this booklet.
However, you cannot modify the booklet without permission from the Information and Support Center for
Persons with Developmental Disorders.

〔パンフレットのご利用について〕 このパンフレットは原則、印刷・配布は自由です。
なお、パンフレットの内容について、発達障害情報・支援センターに無断で改変をおこなうことはできません。

発行：国立障害者リハビリテーションセンター 企画情報部 発達障害情報・支援センター

Information and Support Center for Persons with Developmental Disorders,

Department of Planning and Information, National Rehabilitation Center for Persons with Disabilities

ウェブサイト <https://www.rehab.go.jp/ddis/>

